

ИНЕГ-ЫН УДИРДЛАГУУД БОЛОН ИКАО-ЫН USOAP АУДИТАД
БЭЛТГЭХ ЗОХИЦУУЛАХ ТӨВИЙН ДУНД ХИЙГДСЭН УУЛЗАЛТЫН
ТЭМДЭГЛЭЛ

2010 оны 1 дүгээр сарын 19

Оролцсон хүмүүс:

С.Итгэл – ЭЗЗХА-ны Ерөнхий менежер
С.Манлай- ЗХНХМХ-ийн дарга
Р.Баатархуяг – НХА-ны дарга
Ц.Бат –НААХЗА-ны ДББХ-ийн дарга
М.Эрдэнэбатмөнх- НААХЗА-ны НСҮАХХ-ийн дарга
Ж.Цолмон – НААХЗА-ны ААХХ-ийн дарга
Н.Ганболд - НААХЗА-ны НТЧХ-ийн дарга
С.Ерөөлт - НААХЗА-ны ҮГХ-ийн дарга
П.Мягмарсүрэн – НААХЗА-ны ОХҮТ-ийн дарга
Д.Гантөмөр – Сургалтын төвийн захирал
Б.Мөнхжаргал – Аэродромын албаны дарга
Ж.Энхболд – Нисэхийн цаг уурын төвийн дарга
С.Мөнхбат – НЦУТ-ийн ерөнхий инженер
Н.Энхбат - НААХЗА-ны ААХХ-ийн байцаагч
П.Ганбаатар - НААХЗА-ны ААХХ-ийн байцаагч
Д.Баяртогтох- ТХА-ны Ерөнхий инженер
М.Номин – ТХА-ны инженер
Б.Сүрэнхорлоо - НААХЗА-ны ҮГХ-ийн ажилтан

ИНЕГ-ын ИКАО-ын аудитад бэлтгэх зохицуулах төв:

- ерөнхий координатор -Д.Батчулуун

- гишүүд /П.Пүрэвсүх, Ө.Батсайхан, Н.Батсайхан, Н. Энхтуяа, П.Гантөгс,
Д.Хишгээ, Т.Алтанзул/

Д.Батчулуун: Үр ашигтай байлгах, харилцан мэдээлэл солилцох үүднээс энд би биш, та бүхэн зогсож мэдээлэл хийж баймаар байна. НААХЗА Мягмар гаригийг аудитад зориулан дотоод ажлын өдөр болгосон. Өнөө өглөө бид НААХЗА-ны хоёр хэлтэс дээр уулзаж ярьлаа. Эндээс харахад, маш их ажил хийдэг боловч хүнд үзүүлэх хэмжээнд байлгаж чаддаггүй юм байна. Бичиг баримтыг цэгцлэхдээ сүүлийн 3-н жилийг үлдээгээд бусдыг нь архивт өгөх нь зүйтэй байна.

Ж.Цолмон: Солонгост байцаагчийн сургалт, дүгнэлт г.м. бүгд кодоор электрон хэлбэрт оруулж үзүүлдэг юм билээ.

Д.Батчулуун: Байцаагч нарын хувийн хэргийг баяжуулах арга хэмжээ авах. Үүнд: давтан сургалт, ОJT г.м. он оноор нь цэгцтэй болгомоор байна. Хүний нөөцийн асуудал задгай байгаа нь харагдаж байна.

С.Манлай: Бичиг баримтын хувьд сүлжээний программыг авсан байгаа, туршилтын шатандаа байна. Бичиг баримт хөтлөх зааврыг харъяа бүх газрын бичиг хэрэгт өгсөн байгаа.

Д.Батчулуун: Манлай даргаа архив, бичиг баримтын асуудлаар ирэх Мягмар гаригийн уулзалт дээр танайхаас танилцуулга хийж энэ хүмүүст нэгдсэн ойлголт өгмөөр байна.

С.Манлай: Болно. Ирэх 7 хоногт хийлгэе.

Д.Батчулуун: Эрх шилжүүлэх асуудлыг хуучин систем рүү шилжүүлэх талаас нь Даваа даргатай ярина. Хүний нөөцтэй холбоотойгоор аэродром, PANS-OPS –ын байцаагч хэрэгтэй байна. Эсхүл энэ ажлыг хийлгэчихээр гадны байгууллага байна уу? Үйлдвэрлэлийнхэн үйл ажиллагааныхаа заавартаа дүрмийн өөрчлөлттэй холбоотойгоор нэмэлт өөрчлөлт хийгээд бүх хөтөлбөр программаа батлуулаад бэлэн байлгах хэрэгтэй байна.

Д.Мөнхжаргал: Манайд, зөвхөн ЭХАТ болон гэрэл суулттай холбоотой асуудлаар 140 дутагдал байна. Эдгээрийг арилгах зорилгоор 8 журам гаргасан. Эдгээр нь одоо болтол Дүрмийн хэлтэс дээр батлагдахгүй байна. Хэзээ, яаж батлах юм, бүү мэд, таг чиг. Ийм баймааргүй байна.

Д.Батчулуун: Дэд зохицуулагч нар СМИС-т бүх мэдээллээ одоо байгаагаар нь шууд бөглө.

Н.Энхбат: Эхлээд юуг аэродромын стандарт гэдгээ тогтоод цааш явах хэрэгтэй байна. СМИС дээр 45% нь гэрчилгээжүүлэлттэй холбоотой тул нэгмөсөн энэ талаар шийд гарсны дараа л бөглөмөөр байна. Наана нь хий дэмий цаг алдаж бөглөмөөргүй байна.

Ц.Бат: ИНД-11 цуцлагдаагүй байгаа тул тэр процедураар буюу ийм хурдаар л дүрэм батлах ажиллагаа явна.

Ө.Батсайхан: Дүрмийг хүлээх шаардлага байхгүй. Хүмүүс юмаа хийдгээрээ хийгээд явж байх хэрэгтэй. Ерөнхий хана нь хүмүүст байна. Хэрэв том хэмжээний өөрчлөлт орохоор байвал энэ талаар дүрэм гэрээлсэн хүмүүс бусаддаа эртхэн хэлэх хэрэгтэй.

Р.Баатархуяг: Албан ёсоор цаасаар шийдээд мэдэгдмээр байна.

Тэмдэглэл хөтөлсөн: Т.Алтанзул